



**ХУД 15-Р ХОРОО, 120-ИЙН УУЛЗВАРЫН ЗҮҮН ХОЙНО ХОЛБООНЫ
СУВАГЧЛАЛЫН ӨРГӨТГӨЛ ХИЙХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**
/...ХУУДАС/

ТАНИЛЦСАН:



А.ГАНТУЛГА
ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Ц.ОДХҮҮ
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:



С.ЗОЛЖАРГАЛ
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:



Т.НАРМАНДАХ
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

**СУВАГЧЛАЛ ШИНЭЭР СУУРИЛУУЛАХ
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР ТД-2024/05**

2024.01.19


1. **Өргөтгөл хийх чиглэл:** Хан-Уул дүүргийн 15-р хороо 120-н уулзварын тэмээтэй хөшөөний зүүн хойно S-C 3-1-1 худгаас S-C 3-2-1 худаг хүртэл
2. **Өргөтгөл хийх болсон шалтгаан:**
 - Худаг сувагчлалын бэлэн байдлыг хангуулах, гэмтэлтэй сувагчлал дээр 2+0 хоолой нэмж холбож сувагчлал өргөтгөх.
3. **Техникийн үндсэн нөхцөл:**
 - ХШ-401 хүрээний S-C 3-1-1 худгаас S-C 3-2-1 худаг хүртэл PVC 110мм диаметр бүхий 2+0 хоолой бүхий сувагчлалыг суурилуулна.

Үүнд:


 - Нийт PVC ф-110 мм-ийн 2+0 эгнээ хоолой бүхий 100 метр сувагчлал шинээр хийх.
 - 10 метр урт туслах замын орц гарц болох чулуун авто замыг сэтэлж, сэргээх.
 - Авто болон инженерийн шугам сүлжээ хөндлөн гарч буй хэсэгт 12 метр ф-273 мм-ийн голчтой ган хоолойд PVC 110-ийн 2+0 эгнээ хоолойг хийж хамгаалах.
 - 2.5 метрийн өргөнтэй 90 метр урт явган хүний өнгөт хавтанг хуулж авч, нөхөн сэргээх.
 - Явган замын 2 талд бордюрыг 180 метр солих.
 - Ногоон байгууламж болох 2 метр зүлэг таарч байгаа тул буцааж сэргээх.
 - 100 метр хамгаалалтын туузыг дэвсэж булаах.
 - 3.1 Угсралтын ажил эхлэхээс өмнө ажлын зураг, техникийн даалгаврын дагуу хийгдсэн эсэхийг МХС ХХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын холбогдох ИТА-аар хянуулж баталгаажуулна.
 - 3.2 Худаг сувагчлалын угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.
4. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**
 - 4.1 Худаг сувагчлалын угсралтын болон газар шорооны ажлыг эхлэхдээ Технологийн удирдлага, төлөвлөлтийн газраас ажил эхлүүлэх зөвшөөрлийг авсан байна.
 - 4.2 Угсралтын ажлын явцыг МХС ХХК-иас томилогдсон инженерийн хяналтан дор Монгол Улсад мөрдөгдөж байгаа **MNS 6668:2017** стандартыг баримтлан ажиллана.
 - 4.3 Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нарийн чанд баримталж ажиллана.
 - 4.4 Угсралтын ажил дууссаны дараа сувагчлалын трассыг МХС ХХК-ийн ТУТГазрын Чанар хяналтын хэлтэст техникийн акты хамт хүлээлгэн өгч мэдээллийн санд тусгуулна.
 - 4.5 Улаанбаатар хотын мэдээллийн санд тусгуулна.
 - 4.6 Угсралтын ажлын явцад захиалагч байгууллагын хяналтан дор технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллана.

5. Угсралтын явцад анхаарах технологийн нэмэлт шаардлагууд:


- 5.1 Газар шорооны ажлын үед бусад инженерийн шугам сүлжээг гэмтээхээс сэргийлж тодруулга авч, давхцаж, хөндлөн огтолж байгаа тохиолдолд зөвшилцөн хамгаалах арга хэмжээ авч ажиллана.
- 5.2 Авто зам, явган хүний зам болон тохижсон зам талбай дээр газар шорооны ажил хийхээр бол холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч, авто замаар сувагчлалыг гаргахдаа “Авто зам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжинд холбооны кабель шугамыг суурилуулах” ерөнхий шаардлага **MNS 6597:2016** стандартыг баримтлаж ажиллана.
- 5.3 Худаг сувгийн суурилуулалтын ажлыг MNS6668:2017 стандартад дурьдагдсан дараах технологийн шаардлагуудыг мөрдлөгө болгон ажиллана.
 - 5.3.1 Сувагчлалын хоолойг зурагт заасан байрлалаар суурилуулна.



- 5.3.2 Газар шорооны ажлыг дараах технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.



- 5.3.3 Худаг хоорондын хоолойг дараах технологийн дагуу угсарч суурилуулна. Хотгор суурилуулахыг хориглоно.



5.3.4 Инженерийн байгууламжтай зэрэгцээ болон хөндлөн огтлолцож байгаа тохиолдолд MNS 6668:2017 стандартын 5-р зүйлийг баримталж ажиллана.